



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС 2019

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



ӨМНӨХ ҮГ

Бизнесийн орчныг тогтмол анхааралтай ажиглаж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр бодлого шийдвэр, зохих арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх нь бизнес эрхлэх таатай тогтвортой орчинг бүрдүүлэхэд маш чухал билээ. МҮХАҮТ нь сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд бизнесийн орчинтой холбоотой судалгаануудыг тогтмол явуулж, судалгааны дүнд гарсан санал зөвлөмжийг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт хүргэж ирсэн.

МҮХАҮТ-аас 2001 оноос эхлэн явуулж байгаа “Бизнес итгэлийн индекс” судалгаагаар бизнесийн орчны ерөнхий төлөв байдал, хөрөнгө оруулалтын орчин, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого, хөрөнгө оруулалт, макро эдийн засгийн үндсэн асуудлууд болох ядуурал, ажилгүйдэл, инфляцийн талаар бизнес эрхлэгчдийн өмнөх жилд өгөх үнэлгээ ба ирэх жилийн хүлээлтийг гаргадаг.

“Бизнес итгэлийн индекс 2019” судалгааг Улаанбаатар хот, орон нутагт явуулж, 1800 гаруй аж ахуйн нэгжийг хамрууллаа. Энэ судалгаанд идэвхтэй оролцсон гишүүн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд судалгааг явуулахад хамтарч оролцсон аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимууд, Мэргэжлийн холбоодод МҮХАҮТ-ын зүгээс талархал илэрхийлж байна.

МҮХАҮТ энэхүү судалгааны тайланг Улсын Их Хурал, Монгол улсын Засгийн газар, яамдууд, төрийн байгууллагуудад хүргэх бөгөөд цаашид бизнесийн орчныг сайжруулах чиглэлд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, бодлогын өмгөөлөл, нөлөөллийн үйл ажиллагаагаа эрчимжүүлэхэд илүү анхаарах болно.

Эдийн засаг бизнесийн орчинд бизнес эрхлэгчдийн өгч байгаа үнэлгээ, цаашдын хүлээлтийг тодорхойлсон энэхүү “Бизнесийн итгэлийн индекс” судалгааны тайлан нь бизнесийн орчны индикатор болохын хувьд Та бүхний мэдээллийн чухал нэг эх үүсвэр болно гэдэгт итгэлтэй байна.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ



АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	2
ХУРААНГУЙ	4
I Бизнес итгэлийн индекс	5
1.1 Бизнесийн орчин	6
1.2 Бизнесийн ашиг орлого	8
1.3 Хөрөнгө оруулалт	9
1.4 Макро эдийн засгийн орчин	10
II БИЗНЕСТ ТУЛГАМДАЖ БАЙГАА ГОЛ АСУУДЛУУД	13
III СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	14

Бизнес итгэлийн индексийн судалгааг 2020 оны 3 дугаар сард Улаанбаатар хот, орон нутагт явуулж, 1800 гаруй аж ахуйн нэгжийг хамрууллаа. Судалгаанд оролцогчдыг бизнесийн үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл 31 хувь нь худалдаа, 25 хувь нь үйлчилгээ, 10 хувь нь барилга, 9 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 25 хувь нь хөдөө аж ахуй, уул уурхай, тээвэр, аялал жуулчлал, мэдээллийн технологи, харилцаа холбооны салбар байна. Оролцсон аж ахуйн нэгжийн 80 хувь нь нэг тэрбум хүртэлх төгрөгийн орлоготой, 90 гаруй хувь нь 200 хүртэлх ажилтантай байна.

Бизнес итгэлийн индексийг бизнесийн орчин, ашиг, орлогын өөрчлөлт, хөрөнгө оруулалт, макро эдийн засгийн орчин гэсэн үндсэн 4 үзүүлэлтээр тооцож гаргадаг. 2017 оноос эхлэн олон улсын аргачлалын дагуу Бизнес итгэлийн индексийг үзүүлэлт бүрээр судалгаанд оролцогсдын эерэг болон сөрөг үнэлгээний зөрүүгээр тооцон гаргадаг болсон.

2019 оны Бизнес итгэлийн индекс 0.45 гарсан ба энэ нь 2018 оны индекстэй ойролцоо эерэг үр дүн болж байна.

Бизнесийн орчин ба макро эдийн засгийн орчны өөрчлөлтийн үнэлгээ 2019 онд өмнөх оныхоос бага хэмжээгээр өссөн дүнтэй гарсан бол ашиг орлого ба хөрөнгө оруулалтын үнэлгээ эерэг боловч өмнөх оныхоос бага хэмжээгээр буурсан дүнтэй гарчээ. Судалгаанд оролцсон нийт бизнес эрхлэгчдийн 55 хувь нь бизнесийн орчин өмнөх жилээс сайжирсан гэсэн эерэг үнэлгээ өгсөн бол дунджаар 27 хувь нь макро эдийн засгийн орчин сайжирсан гэж үзжээ.

Ашиг орлогын өөрчлөлтийн үнэлгээний хувьд судалгаанд оролцогчдын 50 хувь нь 2019 онд өссөн гэсэн эерэг хариултыг өгсөн нь өмнөх жилийнхтэй харьцуулахад 8 нэгж хувиар нэмэгдсэн байна. Хөрөнгө оруулалтын үнэлгээнд эерэг хариулт 68 хувь байгаа нь өмнөх оныхтой ойролцоо гарчээ.

Бизнесийн орчны 2020 оны хүлээлтийн хувьд нийт судалгаанд оролцогчдын 31 хувь нь сайжирна гэсэн нь 2018 онтой харьцуулахад 35 хувиар огцом буурсан бөгөөд 2016-2017 оны эдийн засгийн хүндрэлийн үеийн хүлээлттэй нэг түвшинд байна. Энэ нь шинэ корона вирусын халдвараас шалтгаалсан дэлхийн эдийн засаг ба том эдийн засгуудын өсөлт буурах таамаглал, Монгол улсад өндөржүүлсэн бэлэн байдалд авч хэрэгжүүлж байгаа хориг арга хэмжээний улмаас бизнест үүсч байгаа хүндрэлүүдтэй шууд холбоотой гэж үзэж байна.

2020 онд судалгаанд оролцогчид макро эдийн засгийн орчны хувьд хүлээлт тааруу байгаа ба үзүүлэлт бүрээр авч үзвэл инфляцийн түвшин хэвээр хадгалагдаж, ажилгүйдэл, ядуурал нэмэгдэнэ гэж үзжээ.

Бизнес эрхлэгчдийн 2020 оны ашиг орлогын хүлээлт 36 хувь байгаа нь өмнөх оны үр дүн 72 хувьтай харьцуулахад 2 дахин буурсан байна. 2020 онд бизнес эрхлэгчдийн хөрөнгө оруулалт хийх хүлээлт нь өмнөх оноос 20 нэгж хувиар буурчээ.


Бизнесийн орчны тулгамдсан эхний гурван асуудалд бизнес эрхлэгчид зээлийн нөхцөл, авилгал, бодлогын тогтворгүй байдал гэж нэрлэсэн нь өмнөх жилийн үр дүнтэй ижилхэн байна.

I БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС

Бизнес итгэлийн судалгаанд бизнесийн орчин, ашиг орлогын өөрчлөлт, хөрөнгө оруулалт, макро эдийн засгийн орчин гэсэн үндсэн 4 үзүүлэлтийг авч үздэг. Бизнес итгэлийн индексийг олон улсын аргачлалын дагуу эдгээр үндсэн үзүүлэлт бүрээр судалгаанд оролцогсдын зэрэг болон сөрөг үнэлгээний зөрүүгээр тооцож гаргасан.

2019 оны Бизнес итгэлийн индекс 0.45 гарсан нь 2018 оны үр дүнтэй харьцуулахад бага зэрэг буюу 0.02 нэгжээр буурсан байна. Бизнесийн орчинд итгэх итгэл 2013-2016 онуудад 4 жил дараалан буураад, 2017 оноос өсч 2018 онд эерэг үнэлгээтэй гарч байсан юм. (Зураг1)


Зураг 1. Бизнес итгэлийн индекс (2013-2019)



Бизнес итгэлийн индексийг үзүүлэлт бүрээр авч үзвэл, 2019 онд бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ нь 0.13 болж 0.01 нэгжээр, макро эдийн засгийн үнэлгээ нь -0.07 болж 0.16 нэгжээр өмнөх оноос өссөн бол, ашиг орлогын өөрчлөлтийн үнэлгээ нь 0.02 болж 0.16 нэгжээр, хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн үнэлгээ нь 0.37 болж 0.03 нэгжээр тус тус буурсан байна.

(Зураг 2, Хүснэгт 1)

Зураг 2. Бизнес итгэлийн индекс, үзүүлэлт бүрээр (2017-2019)



Бизнес итгэлийн индекс ба үндсэн үзүүлэлт тус бүрийн 2012-2019 үнэлгээний дүн, 2019 оныг 2018 онтой харьцуулсан өөрчлөлтийг Хүснэгт 1-ээр үзүүллээ.

Хүснэгт 1. Бизнес итгэлийн индекс, үзүүлэлт тус бүрээр (2012-2019)

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	Δ
Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ	0.03	0.04	-0.28	-0.46	-0.36	-0.07	0.12	0.13	+0.01
Ашиг, орлогын өөрчлөлтийн үнэлгээ	0.28	0.11	-0.01	0.1	-0.22	-0.02	0.18	0.02	-0.16
Хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн үнэлгээ	0.5	0.02	-0.1	-0.22	-0.3	0.14	0.4	0.37	-0.03
Макро эдийн засгийн орчны үнэлгээ	-0.23	-0.45	-0.47	-0.46	-0.3	-0.37	-0.23	-0.07	+0.16
Бизнес итгэлийн индекс	0.58	-0.27	-0.87	-1.04	-1.18	-0.32	0.47	0.45	-0.02

1.1 БИЗНЕСИЙН ОРЧИН

2019 оны хувьд Монгол улсын эдийн засаг, бизнесийн орчинд дэлхийн зах зээлд зэсийн үнэ буурсан, Оюу толгойн ил уурхайн эрдсийн агууламж багассан, нүүрсний үйлдвэрлэл 11-12 дугаар саруудад буурсан зэрэг сорилтууд тулгарсан боловч макро эдийн засгийн тогтвортой байдал, дотоод эрэлтийн идэвхжил, хувийн хөрөнгө оруулалтын өсөлт, зарим эрдэс түүхий эдийн үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдсан зэрэг нь эерэг нөлөө үзүүлж бизнесийн болон өрхийн орлогын түвшин нэмэгдэж, эдийн засгийн идэвхижил үргэлжлэн 2019 онд Монгол улсын эдийн засаг урьдчилсан гүйцэтгэлээр 5.1 хувиар¹ өссөн. Дэлхийн банкны тайлангаас харахад цаашид эдийн засгийн өсөлтийг тэтгэх гол хүчин зүйлс нь гол салбаруудын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хувийн хэрэглээг дэмжихэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх нь оновчтой гэж үзсэн байна.

Бизнес итгэлийн индексийн судалгаагаар 2019 оны бизнесийн орчны өөрчлөлтөнд судалгаанд оролцогсдын 55 хувь нь өмнөх жилээс “сайжирсан” үнэлгээ өгсөн ба энэ үзүүлэлт нь өмнөх онтой ойролцоо буюу 1 нэгж хувиар өссөн дүн байна. Харин бизнес эрхлэх орчин өмнөх жилээс тодорхой хэмжээнд “муудсан” гэж нийт судалгаанд оролцогчдын 42 хувь нь үзсэн нь өмнөх онтой ижил байна.


2018 онд нийт судалгаанд оролцогсдын 66 хувь нь 2019 онд бизнесийн орчин сайжирна гэсэн хүлээлттэй байсан бол 2019 оны бизнес эрхлэх орчны бодит байдалд 55 хувь нь сайн үнэлгээ өгчээ. Бизнесийн орчны үнэлгээ 2018 ба 2019 онуудад ойролцоо дүнтэй, дараа жилийн бизнесийн орчны хүлээлтийн эерэг үнэлгээ өссөн дүнтэй байснаас үзвэл бизнесийн орчин харьцангуй тогтвортой байсан гэж дүгнэж болно. (Зураг 3)

2020 онд аялал жуулчлал, тээвэр, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарын аж ахуйн нэгжүүдэд бизнесийн орчин маш ихээр муудна гэсэн хүлээлттэй байна.

¹Үндэсний Статистикийн Хорооноос мэдээлсэн эдийн засгийн өсөлтийн урьдчилсан гүйцэтгэлийн дүн.

Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ, хүлээлтийн үзүүлэлтийг Монгол улсын эдийн засгийн өсөлттэй харьцуулсан графикийг Хавсралт 1-т үзүүлэв.

Зураг 3. Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ ба хүлээлт




Дараа жилд бизнесийн орчин сайжирна гэсэн хүлээлт сүүлийн 3 жил дараалан өссөн дүнтэй байсан бол энэ жил судалгаанд оролцогсдын ердөө 31 хувь нь 2020 онд бизнесийн орчин “сайжирна” гэж төсөөлж байна. Энэ нь бизнесийн орчин сайжрах талаар 2019 оны хүлээлтээс 35 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Ийнхүү хүлээлт огцом буурсныг шинэ корона вирусын тархалтын улмаас олон улсад бий болсон нөхцөл байдал, Монгол улсад өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор эдийн засаг, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд үүссэн хүндрэлээс шалтгаалсан гэж үзэж байна.

1.2 БИЗНЕСИЙН АШИГ ОРЛОГО

Бизнесийн ашиг орлогын хувьд 2019 онд нийт судалгаанд оролцогсдын дунджаар 50 хувь нь өмнөх жилээс ямар нэг хэмжээгээр өссөн гэж хариулсан ба энэ үзүүлэлт өмнөх жилээс 8 нэгж хувиар буурсан байна.

Зураг 4. Ашиг орлогын өөрчлөлтийн үнэлгээ ба хүлээлт



2018 оны судалгаагаар бизнес эрхлэгчдийн 72 хувь нь 2019 онд бизнесийн ашиг, орлого сайжирна гэж төсөөлж байсан бол 2019 оны бодит үнэлгээгээр 50 хувь нь өссөн гэж үнэлсэн байна. Харин 2020 онд ашиг орлого хэрхэн өөрчлөгдөх тухай асуулгад нийт судалгаанд оролцогсдын 36 хувь нь өснө гэсэн хүлээлттэй байгаа нь өмнөх жилээс 2 дахин буурсан үзүүлэлт болжээ. Ашиг орлогын хүлээлт нь 2017-2018 онуудад дараалан өсч байсан юм.

Судалгаанд оролцсон тээвэр, барилга, аялал жуулчлал, худалдаа, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын аж ахуйн нэгжүүдийн 50-60 хувь нь 2020 онд ашиг, орлогын түвшин буурна гэсэн хүлээлттэй байна.

Ашиг орлогын өөрчлөлтийн үнэлгээ, хүлээлтийн үзүүлэлтийг Монгол улсын нэгдсэн төсөв дэх татварын орлоготой харьцуулсан графикийг Хавсралт 2-т үзүүлэв.²

1.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


Дэлхийн банкны тайланд 2020 онд худалдаа, хөрөнгө оруулалтын идэвхижил нь дэлхий дахинд эдийн засгийн өсөлтийг хурдасгах гол хүчин зүйлс болно гэж үзжээ. Харин Монгол улсад 2019 оны эхний 9 сарын байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал өндөр байсан нь нийт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн хөрөнгийн хуримтлал жилийн 24.5 хувиар өссөн байна. Гэвч 2018 оны мөн үеийн 35.7 хувийн өсөлттэй харьцуулахад бага үзүүлэлт байна. ГШХО нь 2018 оны эхний 9 сард ДНБ-ий 11 хувьтай тэнцэж байсан бол 2019 оны мөн үед ДНБ-ий 10 хувь буюу гүйцэтгэл нь сайн хэвээр байна. Монгол улсын эдийн засаг хөрөнгө оруулалт, түүний дотор ГШХО-оос өндөр хамааралтай хэвээр байж хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтийг эрэлт талаасаа голлон тэтгэсээр байна.

2019 онд бизнестээ ямар нэгэн хөрөнгө оруулалт хийсэн эсэх талаар бизнес эрхлэгчдээс асуухад судалгаанд оролцогсдын 68 хувь нь хөрөнгө оруулалт хийсэн гэж хариулсан ба энэ нь өмнөх оноос 2 нэгж хувиар буурсан дүнтэй байна. Бодитойгоор хөрөнгө оруулалт хийсэн гэсэн энэ үнэлгээг 2018 оны судалгааны хөрөнгө оруулах хүлээлтийн дүн болох 78 хувийн төсөөлөлтэй харьцуулахад 10 нэгж хувиар доогуур гарсан байна. (Зураг 5)

Бизнесийн хөрөнгө оруулалт хийх талаар асуухад 58 хувь эерэг хүлээлттэй байгаа нь өмнөх жилийн 78 хувийн хүлээлтээс 20 нэгж хувиар буурсан үзүүлэлт бөгөөд энэ нь 2016 оноос хойш хөрөнгө оруулалтын хамгийн бага хүлээлт болж байна.

² Дэлхийн банк групп

Зураг 5. Хөрөнгө оруулалтын үнэлгээ ба хүлээлт



Хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ, хүлээлтийн үзүүлэлтийг Монгол Улсын нийт хөрөнгө оруулалттай харьцуулсан графикийг Хавсралт 3-т үзүүлэв.

1.4 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

Бизнес итгэлийн индексийг тооцоход ашигладаг 4 дэх үзүүлэлт нь макро эдийн засгийн орчин буюу инфляци, ажилгүйдэл, ядуурлын түвшний үнэлгээ ба хүлээлт юм.

2019 онд эдийн засгийн сэргэлт үргэлжилж, хөрөнгө оруулалтын хуримтлал нэмэгдэн ажилгүйдлийн түвшин 6.6% болж буурсан. Мөн өрхийн бодит орлого сүүлийн 11 улирал дараалан бодитоор өсч, дотоод эрэлт идэвхжин эрэлтийн гаралтай инфляцийг бий болгож байсан боловч зээлийн өсөлт эрчтэй саарсантай холбоотойгоор инфляцийн түвшин буурсан байна. Ядуурлын түвшний хувьд өрхийн нийгэм эдийн засгийн судалгаагаар 2018 онд улсын хэмжээнд ядуурлын түвшин 28.4 хувьд хүрч 2016 оны түвшнээс 1.2 нэгж хувиар буурсан боловч хот, суурин газар дахь ядуурал ялимгүй өссөн дүнтэй байгаа ба эдийн засгийн тогтвортой өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэх сорилтууд тулгараад байна.³

Харин бизнес итгэлийн индекс судалгаагаар макро эдийн засгийн үндсэн асуудлууд болох инфляцийн түвшин, ажилгүйдлийн түвшин, ядуурлын түвшин зэрэг үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн “сайн” гэсэн дундаж үнэлгээ нь өмнөх онтой харьцуулахад 3 нэгж хувиар өсч 27 хувь болсон бол 34 хувь нь өмнөх оноос ямар нэгэн дорвитой өөрчлөлт гараагүй эсвэл нөхцөл байдал муудсан гэж үзсэн байна.

³Ядуурлын дүр төрх-2018, Дэлхийн банк групп, Үндэсний Статистикийн Хороо

ИНФЛЯЦИ

Судалгаанд оролцогсдын 29 хувь нь 2019 онд инфляцийн түвшинг нь ямар нэг хэмжээгээр буурсан гэж үзсэн ба энэ нь өмнөх оныхоос 3 нэгж хувиар өссөн үзүүлэлт байна. Харин судалгаанд оролцогсдын 59 хувь нь инфляцийн түвшин тодорхой хэмжээгээр нэмэгдсэн гэж үзсэн нь өмнөх оноос 3 нэгж хувиар өсчээ. (Зураг 6)

2018 онд судалгаанд оролцогсдын 23 хувь нь инфляцийн түвшин буурах хүлээлттэй байсан бол бодит үнэлгээгээр 29 хувь нь инфляцийн түвшин өссөн гэж үзжээ. 2020 онд хэрхэн өөрчлөгдөх талаар асуухад 23 хувь нь инфляцийн түвшин өснө гэж хариулсан нь өмнөх онтой ижил үр дүн байна. Мөн судалгаанд оролцогчдын 40 хувь нь ирэх жил инфляци ямар нэг хэмжээгээр өснө гэсэн хүлээлттэй байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 11 нэгж хувиар буурчээ.

Зураг 6. Инфляцийн өөрчлөлтийн үнэлгээ ба хүлээлт




АЖИЛГҮЙДЭЛ

2019 онд судалгаанд оролцогсдын 28% нь ажилгүйдэл буурсан гэсэн хариулт өгсөн ба энэ дүн нь өмнөх оноос 2 нэгж хувиар өссөн байна. Харин 2018 онд судалгаанд оролцогсдын 43 хувь нь ажилгүйдлийн түвшин ямар нэг хэмжээгээр өссөн гэж үзэж байсан бол энэ дүн 2019 онд 30 хувь болж өмнөх оноос 13 нэгж хувиар буурсан дүнтэй байна. (Зураг 7)

2020 онд ажилгүйдлийн түвшин хэрхэн өөрчлөгдөх тухай тодруулан асуухад судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 21 хувь нь дараагийн жилд ажилгүйдлийн түвшин буурна гэж хариулсан бөгөөд энэ нь өмнөх оноос 12 нэгж хувиар буурсан байна. Ажилгүйдлийн түвшинг судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 63 хувь нь өснө гэж хариулсан ба энэ нь өмнөх оноос 20 нэгж хувиар өссөн дүн юм.

Зураг 7. Ажилгүйдлийн түвшний өөрчлөлтийн үнэлгээ ба хүлээлт



ЯДУУРАЛ

Судалгаанд оролцогсдын 24 хувь 2019 онд ядуурал буурсан гэж үзсэн ба энэ нь 2018 оны үнэлгээтэй харьцуулахад 5 нэгж хувиар өссөн байна. 2019 онд судалгаанд оролцогсдын 64 хувь нь ядуурлын түвшин хэвээр, өссөн гэж үзсэн нь өмнөх оноос 2 нэгж хувиар буурсан байна. (Зураг 8)

Ядуурлын түвшний талаар судалгаанд оролцогсдын 19 хувь нь ирэх жил буурна гэсэн хүлээлттэй байгаа нь өмнөх жилтэй харьцуулахад 9 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм.

Зураг 8. Ядуурлын түвшиний өөрчлөлтийн үнэлгээ ба хүлээлт



II БИЗНЕСТ ТУЛГАМДАЖ БАЙГАА ГОЛ АСУУДЛУУД

Дэлхийн банкнаас орнуудын эдийн засгийн үр ашигтай байдлыг хэмжих зорилготой Бизнес эрхлэлтийн индекс (Doing business index)-ийг гаргадаг. Мөн дэлхийн банкны эдийн засагчдын хийсэн судалгаагаар Бизнес эрхлэлтийн индекс ба тухайн орны бүтээмж нь хоорондоо эерэг хамааралтай байдаг бөгөөд Бизнес эрхлэлтийн индекс өндөртэй орон нь илүү өндөр бүтээмжтэй байдаг байна. Өөрөөр хэлбэл бизнесийн тогтвортой, сайн орчин нь илүү өндөр бүтээмжийг бий болгодог байна.

Иймд энэ хэсэгт бизнесийн орчинд тулгамдаж байгаа, нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлын талаар судалгаанд оролцогсдын үнэлгээг нэгтгэн сүүлийн гурван жилийн дүнг харьцуулан дараах хүснэгтээр үзүүллээ. “Зээлийн өндөр хүү, хугацаа” гэсэн асуудлыг сүүлийн гурван жил дараалан хамгийн тулгамдаж буй асуудлаар нэрлэсэн байна.

Хүснэгт 2. Бизнес тулгамдаж байгаа гол асуудлууд

Эрэмбэ	2017	2018	2019
1	Зээлийн өндөр хүү/ богино хугацаа	Зээлийн өндөр хүү/ хугацаа	Зээлийн хүү, хугацаа
2	Бодлогын тогтворгүй байдал	Бодлогын тогтворгүй байдал	Авилгал, хээл хахууль
3	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт)	Авилга, хээл хахууль	Бодлогын тогтворгүй байдал
4	Хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт)	Хүнд суртал
5	Авилга, хээл хахууль	Хүнд суртал	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт)
6	Төрийн албаны нүсэр бүтэц	Хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал	Хуулийн хэрэгжилт хангалтгүй
7	Төрийн хүнд суртал	Төрийн нүсэр бүтэц	Тендерийн шалгаруулалтын шударга бус байдал

III СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ


Судалгааг 2020 оны 3 дугаар сарын 9-27-ны өдрүүдэд Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчдийн дунд асуулгын ба онлайн хэлбэрээр явуулж нийт 1834 аж ахуйн нэгжийг хамруулсан.

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн 37 хувь нь 100 сая төгрөг хүртэл жилийн орлоготой, 43 хувь нь 101 саяас 1 тэрбум хүртэл төгрөгийн орлоготой, 20 хувь нь 1 тэрбумаас дээш орлоготой байна. Ажиллагсдын тооны хувьд 60 хувь нь 19 хүртэл, 33 хувь нь 20-199, 7 хувь нь 200-аас дээш байна. Бизнесийн үйл ажиллагааны салбараар 31 хувь нь худалдаа, 25 хувь нь үйлчилгээ, 10 хувь нь барилга, 9 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүд байна.


Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээллийг дараах хүснэгтээр үзүүлэв.



Хавсралт 1. Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ, хүлээлт ба Монгол улсын эдийн засгийн өсөлт



Хавсралт 2. Ашиг орлогын өөрчлөлтийн үнэлгээ, хүлээлт ба нэгдсэн төсөв дэх татварын орлого



Хавсралт 3. Хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ, хүлээлт ба МУ-ын нийт хөрөнгө оруулалт

